

ЭРДЭНЭЦАГААН СУМ

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН МЭДЭЭ

Хууль, эрх зүй, удирдлага зохион байгуулалтын хүрээнд:

Орон нутгийн дайчилгааны сургалт 6 дугаар сарын 22-29 ны хооронд явагдаж өнгөрсөн. Нийтдээ 150 орчим хүн оролцсон. БИНХ-р “ХҮНСНИЙ ЗОРИУЛАЛТЫН БУС ХУВАНЦАР САВНЫ ХЭРЭГЛЭЭНЭЭС ТАТГАЛЗАЖ ХАВДАР ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ” 3 САРЫН АЯНЫ ажлын хүрээнд иргэдэд ухуулга сурталчилгаа хийж сумын засаг даргын нөөц сангаас 1.0 сая төгрөгийн дэмжлэгээр нэг багт 5 ш бүгд 40ш сав суулгыг сугалаагаар олгож, 680ш гарын авлага иргэдэд түгээж ажилласан. ЗДТГ-ын пейж хуудсаар дамжуулан цахим сурталчилгааг өдөр бүр хийж байна.

ЕБС"

АХИЦ-АМЖИЛТ-ҮР ДҮН" Ерөнхий боловсролын 16 сургуулийн 2022-2023 оны хичээлийн жилийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэх, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх удирдах ажилтны сургалт семинар зохион байгуулагдаж байна.

ОНХС-ын хөрөнгө оруулалтаар сургуулийн 100 гаруй багш ,ажилтан 1400 гаруй сурагчдынхаа ажиллах, сурах орчинг бүрдүүлэх зорилгоор

-  Хичээлийн 1,2-р байр
-  1,2-р Дотуур байр
-  Үдийн хоолны гал тогоо
-  Дотуур байрын гал тогоо
-  20 анги танхим буюу 40 бүлэгт

тоног төхөөрөмжийг амжилттай суурилууллаа.

УНШИХ (EGRA) БА БОДОХ (EGMA) ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙН ТУРШЛАГА СУДЛАХ, СУРАЛЦАХ ЗӨВЛӨГӨӨНД нийт 16 сургуулийн 16 сайн туршлага амжилттай солилцлоо.

Сургуулийн өмнөх боловсрол:

Бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх, соёл урлагийн үйлчилгээгээр дамжуулан гоо зүйн мэдлэг олгох, СӨБ-ын насны хүүхдийн хөгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор "СОЁЛТОЙ ХАМТ"-соёлын явуулын үйлчилгээг Хүүхдийн 1-р цэцэрлэгт хөтөлбөрт 3 өдрийн арга хэмжээг төлөвлөн зохион байгуулж ажиллалаа. Сумын Соёлын төвөөс “ Соёлын боловсролыг дээшлүүлэх” аяны хүрээнд Бэлтгэл ангийн хүүхдүүдийн дунд зохион явуулсан “Музейн боловсрол олгох” зургийн уралдаанд музейгээр зочилж үзсэн зүйлсээ дүрслэн зурах уралдаанд амжилттай оролцсон.

Сургуулийн өмнөх боловсролын шинэчлэл ТББ-аас уламжлал болгон зохион байгуулагддаг “Цэгээр наадъя –Урлагийн цахим наадам ” улсын хэмжээний уралдаанд амжилттай оролцсон.

Хүүхдийн сурч хөгжих таатай орчинг бүрдүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж 4р багийн харъяат Аймгийн сайн малчин, ИХТөлөөлөгч Ш.Банзрагч, гэргий Д.Гуатуяа нар цэцэрлэгийн хүүхддүүдэд зориулж гулсуур бэлэглэсэн.

“Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг дэмжих орон нутгийн сургагч багш бэлтгэх” сургалтыг 2023 оны 05 сарын 23 ны өдөр Багш ажилчдаа түгээн дэлгэрүүлэлт хийлээ. Сургуулийн өмнөх боловсролын 24 байгууллагын 2022-2023 оны хичээлийн жилийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэх, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх СӨББ-ын удирдах ажилтны сургалт Сүхбаатар аймагт болсон.

БШУЯ, НҮБ-ийн Хүүхдийн сан, МУБИС-ийн Нийгмийн ажил, арга зүйн тэнхимээс хамтран зохион байгуулсан, туршлага солилцох үйл ажиллагаанд цэцэрлэгийн агра зүйч нар оролцлоо.

Санхүүгийн чиглэлээр: 2023 оны 6-р сарын орлогыг хааж тус онд олгосон санхүүжилтийг байгууллагын нягтлан бодогч нартай тулган баталгаажуулан ажилласан. Өмнө онуудад өгсөн акъ албан шаардлагын биелэлтийн тайланг хүргүүлсэн.

2023 оны 6-р сарын орлогыг хааж төвлөрүүлсэн.

1. Цалин, хөлс түүнтэй адилтгах орлого -255,639,033.05
2. Үйл ажиллагааны орлого – 1,014,792.66
3. Хөрөнгийн орлого -18,995,439.10
4. Шууд бус орлого – 77,055,820.14
5. Малын тоо толгойд огдуулах албан татвар – 34,372,500
6. Бууны албан татвар – 564,000
7. ҮХХАТ- 9,354,807.84
8. Байгалын ургамлын нөөц ашигласны албан татвар – 2,023,900
9. Улсын тэмдэгтийн хураамж- 1,117,800
10. Хог хаягдлын үйлчилгээний төлбөр – 372,000
11. Газрын төлбөр- 43,700,818
12. Торгуулийн орлого – 19,369,000 нийт 12 нэр төрлийн 463,579,910.8

төгрөгийн орлого төвлөрүүлэн хаалтыг хугацаанд хийж орлогыг 51%-ийн биелэлттэй төвлөрүүлэн ажиллаа. Аймгийн санхүүгийн дэмжлэг хувиараар 258,922,000 төгрөгийн санхүүжилт ирсэнээс орон нутгийн 3 байгууллага, ТЗШ-ын 5-н байгууллагад 721,599,600 төгрөгийн санхүүжилтийг олгож, 2023 оны 6-р сард 769 ширхэг гүйлгээг хянаж батлан 5,761,145,279 төгрөгийн гүйлгээ хийгээд байна. Төсвийн ерөнхийлөөн захирагчийн 2022 оны нэтгэсэн тайланг өөрчлөлтгүй дүгнүүлж ажилласан.

Мэдээлэл технологийн ажлын хүрээнд:

- “Засаг даргын тамгын газар” пэйж хуудасаар дамжуулж цаг үеийн мэдээ мэдээллийг нийтэлж олон нийтийг мэдээллээр хангаж ажиллаа.

E-Mongolia.mn, Төрийн үйлчилгээний цахим системийн хүрээнд:

Д/д	Үйлчилгээний тоо			Хамгийн их үзүүлсэн 10 үйлчилгээ	
	Нийт	Төлбөртэй	Төлбөргүй	Нэр	Тоо
1	5		6	Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт	6
2			5	Иргэний үнэмлэхийн лавлагаа	5
3			4	Иргэний оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн лавлагаа	4
4			0	Жолоочийн лавлагаа, мэдээлэл	0
5			25	Хилийн цэргийн төв архив - Хугацаат цэргийн алба хаасан тухай лавлагаа	25
Нийт		0	40		40

Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Сумын хэмжээнд төл малын мэдээ 147853 толгой эх мал төллөж 72,0 хувьтай байна. Ингэ 86, гүү 7982, үнээ 9878, эм хонь 72582, эм ямаа 57325 төллөсөн сумын хэмжээнд эх малын төллөлт нийтдээ 72,0 хувьтай. Төлийн хорогдол нийт 1408 үүнээс унага 32, тугал 21, хурга 380, ишиг 975. Төл бойжилт 99 хувьтай байна.

Том малын хорогдлын мэдээ тэмээ 2, адуу-153, үхэр-142, хонь-1442, ямаа-2176 нийт 3915 толгой мал хорогдсон байна. Үүнээс баталгаажуулсан хээлтүүлэгч мал 249 хорогдсоноос хуц-125, ухна-124 хорогдоод байна. Улсын төсвөөр 1 худаг гаргасан. Малчид өөрсдийн хөрөнгөөр 5 гар худаг гаргасан. /12,5 сая төгрөг/. Бэлчээрийн хортон мэрэгч амьтантай тэмцэх ажлыг зохион байгуулан 1,7,8-р багийн нутаг дэвсгэрт 5000 га газарт үлийн цагаан огтоны хор цацсан. Энэ ажилд 15 хүн оролцож ажилласан. 100 л шатахуун буюу 370000 төгрөг зарцуулсан. Өөр аймаг сумаас отроор явж байгаа 25 өрхийн 18900 толгой мал зунжиж байна. Эдгээр айл өрхүүдэд газар нутаг чөлөөлж нүүх талаар мэдэгдэх хуудас өгсөн. Сүүний үхрийн 2 эрчимжсэн аж ахуй, 2 иргэн үйл ажиллагаа явуулж сумын албан байгууллага, иргэдэд сүү, цагаан идээгээр үйлчилж байна. Сүүний чиглэлийн 15 үнээ, нутгийн монгол үнээ 40 толгой байна. 2 иргэн тахиа үржүүлж байгаа бөгөөд Өндөглөгч тахиа нь 16, азарган тахиа 5 байна. “Үзэмчин хонь” үржлийн нэгж нь сумын засаг даргатай

хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Сумын ИТХ-аар орон нутгийн мал сүрэгт үзлэг ангилалт хийхээр 10 сая төгрөгийг төсөвт суулгуулсан. Тус үржлийн нэгж нь 4700 толгой малд үзлэг ангилалт, ээмэгжүүлэлт хийх гэрээгээ 2023 оны 6-р сарын 7 нд байгуулсан. Хөдөө аж ахуйн тасаг үржлийн нэгжтэй хамтран 150 хурган хуц, 55 ишгэн ухна шилэн сонголт хийж шинээр тавьсан. Махны чиглэлийн 15 бухан бяруу аймгийн ХААГ-т захиалаад байна

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр Ажлын байр дэмжих төсөл Г.Отгон-Эрдэнэ Блок 9,0 сая, ахмадын төсөлд В.Март Бууз банш, хэрчсэн гурил 3,0 сая, ахмадын зөвлөх үйлчилгээг сургууль, засаг даргын тамгын газар гэсэн 2 байгууллага төсөл авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Малжуулах төсөлд 13 төсөл хүлээн авч АДЗ-өөр хэлэлцэн квотын дагуу 6 төслийг дэмжиж аймагт ХХҮГ-т хүргүүлээд хянагдаж байна. Мөн хүнд машины опреторын сургалтанд 6 залуу сурч байна.;

Тайлан бичсэн: ХЭЗ,ХШҮ- хариуцсан мэргэжилтэн Д.Жагварал.